

Ипотекийн зээлийн тайлан

2016 оны 7 дугаар сар


Банкууд 2016 оны 7 дугаар сард нийт 1592 зээлдэгчид 92.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3856.3 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 85622-д хүрчээ. Тайлант сард 5%-ийн хүүтэй 26.4 тэрбум төгрөгийн зээлийг 569 зээлдэгчдэд олгосон бол 8%-5% руу 117 зээлдэгчдийн 5.2 тэрбум төгрөгийн зээлийг шилжүүлжээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 0.3 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 10.3 нэгж хувиар буурч 19.4 хувьд хүрсэн байна.



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.7 хувь буюу 2995.8 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 5 болон 8 хувийн хүүтэй зээл, 5 болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 20.7 хувь буюу 799.3 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.6 хувь буюу 61.2 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр



2016 оны 7 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.1 хувь нь төгрөгийн зээл, 0.9 хувь нь валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2016 оны 7 дугаар сарын байдлаар 3.4 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.2 байна.



Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 32.7 хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар тус тус өссөн байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 90.2 хувь буюу 83.7 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 9.8 хувь буюу 9.1 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 7 дугаар сарын байдлаар 58.3 сая төгрөг байна.

Тухайн сард 37.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 55.7 хувиар өссөн бол өмнөх сараас 10.6 хувиар буурсан байна.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1592 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1388 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 204 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




2016 оны 7 дугаар сарын байдлаар нийт 85622 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 63146 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд (үүнээс 2778 нь 5 хувийн хүүтэй зээлд, 1146 нь 8 хувиас 5 хувь руу шилжсэн зээлд хамрагджээ), 20611 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1865 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 3 сараас 30 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 19.5 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2016 оны 7 дугаар сарын байдлаар 16.3 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 43.0 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. Харин нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.9 хувь нь 16-20 жил, 17.0 хувь нь 11-15 жил, 9.1 хувь нь 6-10 жил, 1.3 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2016 оны 7 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 7.72 хувь болжээ. Энэ нь өмнөх сараас төдийлөн өөрчлөлтгүй байгаа бол өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 13.8 хувь байв. ОСИСТБХ –ийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 оны 3 дугаар сараас 6.4 хувь болж буурсан байна.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2008	12	217,977.5		8.4	19.8	16,522	
2009	12	226,040.6		8.6	18.7	16,784	
2010	12	333,776.6		9.6	16.0	16,700	
2011	12	669,662.8		12.9	14.8	26,869	
2012	12	845,204.4		13.0	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	16.1	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	16.2	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	16.1	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	15.9	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	16.0	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	15.8	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	15.2	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	15.7	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	15.6	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	15.5	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	15.8	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	16.2	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	16.7	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	16.3	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	16.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	16.5	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	16.6	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	16.4	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	16.4	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	16.1	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	16.3	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	16.2	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	16.8	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	16.4	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6	16.7	8.8	77,105	55,830
2016	1	3,434,849.9	2,595,234.1	16.3	10.1	77,226	56,031
	2	3,459,596.6	2,623,837.0	16.6	9.2	77,673	56,577
	3	3,565,321.5	2,679,829.3	17.1	8.8	81,015	57,659
	4	3,632,982.1	2,751,292.4	16.1	8.2	82,320	59,001
	5	3,704,168.2	2,832,261.7	16.2	8.3	83,280	60,455
	6	3,799,387.7	2,929,375.2	16.4	7.7	84,906	62,080
	7	3,856,332.4	2,995,847.0	16.3	7.7	86,622	63,146

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 7 дугаар сарын байдлаар

2016 оны 7 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.6 хувийг Улаанбаатар хотод, 23.4 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.0 хувь буюу 126.3 тэрбум төгрөг Орхон аймагт, 13.8 хувь буюу 125.1 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 8.7 хувь буюу 78.7 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,952,321.8	76.56	2,414,516.3	80.60	21.1	8.3	57537	43,816
2 Орхон	126,282.8	3.27	88,875.5	2.97	12.0	5.5	3215	2,740
3 Дархан-Уул	125,133.8	3.24	95,975.5	3.20	21.7	6.5	3639	3,109
4 Дорноговь	78,719.1	2.04	54,404.6	1.82	14.1	5.8	2271	1,790
5 Дорнод	57,670.3	1.50	42,473.7	1.42	21.7	5.6	1830	1,576
6 Увс	52,327.7	1.36	28,664.0	0.96	13.7	6.7	1678	879
7 Сэлэнгэ	50,127.5	1.30	35,049.6	1.17	14.1	9.4	1705	1,150
8 Өвөрхангай	47,907.5	1.24	29,435.7	0.98	17.3	6.2	1677	909
9 Өмнөговь	44,933.4	1.17	29,138.1	0.97	12.9	7.5	1244	869
10 Ховд	44,506.0	1.15	25,608.0	0.85	17.9	5.9	1411	1,037
11 Баянхонгор	32,937.0	0.85	19,421.8	0.65	16.9	5.6	1036	758
12 Сүхбаатар	31,814.6	0.82	18,617.1	0.62	16.8	7.9	1046	646
13 Архангай	29,308.2	0.76	16,862.8	0.56	14.8	5.0	848	556
14 Баян-Өлгий	25,837.5	0.67	10,774.4	0.36	15.6	6.5	1166	387
15 Хөвсгөл	22,876.1	0.59	9,263.2	0.31	14.3	5.4	878	279
16 Говь-Алтай	22,816.7	0.59	15,900.7	0.53	16.5	5.9	740	522
17 Завхан	22,462.0	0.58	10,806.6	0.36	15.5	6.9	805	346
18 Хэнтий	22,115.8	0.57	12,525.3	0.42	12.1	6.2	652	480
19 Төв	19,358.9	0.50	10,547.5	0.35	16.6	7.8	611	342
20 Дундговь	17,923.0	0.46	10,400.9	0.35	12.7	8.4	589	378
21 Булган	14,945.9	0.39	5,633.6	0.19	10.8	9.3	528	199
22 Говьсүмбэр	14,007.0	0.36	10,952.0	0.37	20.0	5.4	516	378
	3,856,332.4	100.00	2,995,847.0	100.00	19.5	7.7	85622	63146